



ХУВИЙН ХЭВШИЛД ТУЛГУУРЛАСАН ӨСӨЛТӨД ХҮРЭХ ЗАМЫН ЗУРАГ 2024

2023-12

МОНГОЛ ДАХЬ АМЕРИКИЙН ХУДАЛДААНЫ ТАНХИМ
ХУВИЙН ХЭВШИЛД ТУЛГУУРЛАСАН ӨСӨЛТӨД ХҮРЭХ ЗАМЫН ЗУРАГ 2024

Энэхүү баримт бичгийг Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
("АмЧам Монгол") боловсруулсан болно.

Бодлогын баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд
АмЧам Монгол-оос зөвшөөрөл авна.

Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан.

2023 оны 12 дугаар сар
Улаанбаатар хот

ОРШИЛ

“Өсөлтөд Хүрэх Замын Зураг” нь Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (цаашид АмЧам Монгол гэх) бодлогын тэргүүлэх чиглэлүүд болон үйл ажиллагааны стратегийг тусгасан бодлогын баримт бичиг бөгөөд Монгол улсад бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, Америкийн бизнес эрхлэгчид болон танхимын гишүүдэд өрсөлдөөний ижил нөхцлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм. Энэхүү стратегийн баримт бичиг нь бизнесийн танхимуудын хүрээнд АмЧам Монголын аль хэдийн хүрсэн тэргүүлэх байр суурийг хэвээр хадгалах, түүнчлэн шинэ арга барил, стратеги дээр тулгуурлан хэрэгжүүлэх бодлогын нөлөөллийн ажлуудыг тодорхойлсон болно.

АмЧам Монгол нь 2024 онд дараахь хэд хэдэн шинэ бодлогын арга хэмжээнүүд хэрэгжүүлэх бөгөөд үүнд зорилтот бодлогын асуудлуудад анхаарлаа хандуулж, татварын цогц шинэчлэл болон татварын маргааныг шийдвэрлэх зэрэг чухал асуудлууд багтаж байна.

Өөр нэг шинэ санаачилга бол 2023 оны 6-р сард амжилттай зохион байгуулсан АмЧам Монголын Doorknock бизнес аялалын мөрөөр АНУ болон Монгол улсын хоёр талын харилцааг улам өргөжүүлэх зорилгоор АНУ-тай харилцах хороог байгуулах явдал юм.

2024 оны 6-р сард болох УИХ-ын сонгууль, улмаар шинэ Засгийн газар байгуулагдах нь гадаадын хөрөнгө оруулалтын талаарх цаашдын бодлогыг тодорхойлоход чухал хүчин зүйл болох нь дамжиггүй. АмЧам Монгол нь шинээр байгуулагдах Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдтэй идэвхтэй хамтран ажиллаж, бодлогын гол мессежүүдийг танилцуулахаар төлөвлөж байна.

2024 оны бодлогын тэргүүлэх үндсэн чиглэлүүд

1. Монгол Улсад хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг дэмжих;
2. АНУ болон Монгол улсын хоёр талын болон гуравдагч хөршүүдтэй хийх худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ялангуяа хөдөө аж ахуйн салбарт АНУ-ын хөрөнгө оруулалтыг татах
3. Гишүүн байгууллагуудын ашиг сонирхолд нийцсэн дэмжлэг үзүүлэх, тэдний брэндийг сурталчлан таниулах.

Үндсэн чиглэлүүдийг дэлгэрэнгүй дурьдвал:

1. Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг дэмжихдээ гуравдагч хөршийн хөрөнгө оруулалтын бодлогод голлон анхаарах, гишүүдийн үйл ажиллагаа эрхэлдэг салбаруудад чиглэсэн эдийн засгийн сэргэлт, өсөлтийг дэмжих, үүнд уул уурхай, ашигт малтмал, хөдөө аж ахуй, санхүүгийн үйлчилгээ, цахим шилжилт, худалдаа арилжаа, эрчим хүч, авто болон агаарын тээвэр зэрэг салбарууд багтана.

Уул уурхайн салбар, экспорт өргөжин тэлж, цар тахлын дараах үйлчилгээний сэргэлт үргэлжилж байгаа тул Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2022 онд 4.7 хувь байсан бол 2023 онд 5.2 хувьд хүрч хурдацтай өсөх төлөвтэй байна. Уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэхийн хэрээр 2024-2025 онд эдийн засгийн өсөлт 6 хувиас дээш гарах төлөвтэй байна¹.

2024 оны зургадугаар сард УИХ-ын сонгууль болох бөгөөд энэ нь ирэх дөрвөн жилд Монголын эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Монгол Улс хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж, бусад орны хөрөнгө оруулалтыг татах, хадгалах гуравдагч хөршийн бодлогыг хэрэгжүүлэх нь нэг чухал юм. Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) Монгол Улсын Засгийн газар хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцаа тогтоохын зэрэгцээ гуравдагч хөрш болон хөгжингүй орнуудын ИШХО-ыг нэмэгдүүлэх ажлыг идэвхтэй үргэлжлүүлэх ёстой гэж үзэж байна. АмЧам Монгол нь эдгээр хүчин чармайлтын Засгийн газар болон бусад бизнес, салбарын холбоо, гүншүүртэй хамтран зохицуулж, удирдан чиглүүлнэ.

2023 оны Монгол Улсын Хөрөнгө Оруулалтын Орчны мэдэгдэлд "Монгол Улс хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байгаа ч бизнес хийх сонирхлоо бодит болгож, хөрөнгө оруулалт татахад бэрхшээлтэй байгаа. Монгол Улс хууль тогтоомжийн хэрэгжилтийн ил тод байдлыг хангаж, бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлэхгүй бол хөрөнгө оруулагчид Монголыг хэтэрхий эрсдэлтэй гэж үзэж, илүү өрсөлдөх чадвартай улс орнуудыг сонгох болно.



¹ <https://www.imf.org/en/Publications/CR/Issues/2023/10/04/Mongolia-2023-Article-IV-Consultation-Press-Release-and-Staff-Report-540108>

Эдгээр эрсдэлийг бууруулах чухал алхам бол Монгол Улс Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар ил тод байдлыг хангах тухай АНУ-Монголын хэлэлцээрийг (Ил тод байдлын гэрээ гэж нэрлэдэг) хэрэгжүүлэх нь шинэ хууль тогтоомж, дүрэм журам эцэслэхээс өмнө олон нийтээс санал авах хугацаа шаарддаг. Монгол Улс энэ гэрээний зарим хэсгийг хэрэгжүүлсэн ч олон нийтэд мэдээлэх үүргээ бүрэн хэрэгжүүлэхээс таван жил гаруй хугацаагаар хоцорч байна²."

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

1. Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн сэргэлт болон өсөлтийг дэмжих:

Зорилтууд

АмЧам Монголын бодлогын нөлөөллийн гол санаачлагууд болон мессежүүдийг улам шат ахиулж, Монгол улсад бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин бий болгох чиглэлээр манлайлсан худалдааны танхим байх

Үйл ажиллагаанууд

- Тодорхой бодлогын сэдвээр сар бүрийн уулзалтуудыг зохион байгуулах;
- Сар бүрийн уулзалтанд гаргасан төлөвлөгөөний дагуу тодорхой илтгэгчдийг сонгож, мэдээлэл хуваалцах;
- Эдийн засгийн үндсэн салбаруудын тулгамдсан асуудлууд, тухайлбал татварын цогц шинэчлэл хийх, татварын маргаан шийдвэрлэх механизмын талаар төр-хувийн хэвшлийн хэлэлцүүлэг өрнүүлэх;
- УИХ, Засгийн газрын бүх шатны байгууллагуудтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх;
- 2024 оны зургадугаар сард болох УИХ-ын сонгуульд өрсөлдөх намуудын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрийг гишүүдэд мэдээлэх зорилгоор 2024 оны сонгуулийн удирдамжийг боловсруулах;
- Монгол Улсын шинэ Засгийн газартай хамтран ажиллахын тулд Doorknock 2024 арга хэмжээг дотооддоо зохион байгуулах

Хүлээж буй үр дүн

- Бодлогын гол мессежүүдийг холбогдох бодлого тодорхойлогчдод хүргэх;
- Бодлогын нөлөөллийн гол асуудлуудаар идэвхитэй үр дүн гарах хүртэл ажиллах;
- Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг сурталчлах;
- Бодлогын нөлөөллийн ажлаараа манлайлагч бизнесийн танхим гэсэн байр сууриа хэвээр хадгалах;
- 2024 оны зургадугаар сард болох УИХ-ын сонгуульд өрсөлдөх намуудын мөрийн хөтөлбөрийн талаар гишүүдэд мэдээлэх зорилгоор 2024 оны сонгуулийн удирдамж (Election Guide)-ийг боловсруулах;
- Есдүгээр сард шинээр байгуулагдах УИХ, Засгийн газар, яамд, төрийн байгууллагуудтай уулзаж, бодлогын гол мессежээ хүргэнэ



² <https://mn.usembassy.gov/2023-investment-climate-statement-mongolia/>

Эдгээр эрсдэлийг бууруулах чухал алхам бол Монгол Улс Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар ил тод байдлыг хангах тухай АНУ-Монголын хэлэлцээрийг (Ил тод байдлын гэрээ гэж нэрлэдэг) хэрэгжүүлэх нь шинэ хууль тогтоомж, дүрэм журам эцэслэхээс өмнө олон нийтээс санал авах хугацаа шаарддаг. Монгол Улс энэ гэрээний зарим хэсгийг хэрэгжүүлсэн ч олон нийтэд мэдээлэх үүргээ бүрэн хэрэгжүүлэхээс таван жил гаруй хугацаагаар хоцорч байна²."

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

1. Хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн сэргэлт болон өсөлтийг дэмжих:

Зорилтууд

Илүү ил тод хууль тогтоох үйл явцад оролцоог улам нэмэгдүүлэх

Үйл ажиллагаанууд

- Дараах хуулийн төслүүдээр олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах. Үүнд:

- о Хөрөнгө оруулалтын хуулийн шинэчилсэн найруулга
- о Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга
- о Татварын маргааныг шийдвэрлэх тухай
- о Татварын багц хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтүүд
- о Арилжааны тухай хуулийн төсөл
- о Төлбөрийн чадваргүй байдлын тухай хуулийн төсөл;

- Гишүүдийнхээ саналыг нэгтгэж, холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх;

- Хуулийн төслүүдэд өгсөн саналуудыг тусгуулах талаар идэвхитэй ажиллах;

- Эдгээр хуулийн төслүүдийн зүйл заалттай зарчмын хувьд санал нийлэхгүй бол өөрчлүүлэх талаар идэвхийлэн ажиллах;

- Ил тод байдлын гэрээг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн төлөө үргэлжлүүлэн ажиллах

Хүлээж буй үр дүн

- Эдгээр хуулийн төслүүдэд саналуудаа тусгуулахад онцгойлон анхаарах;

- Эдгээр хуулийн төслүүд нь ГШХО-ыг татах болон хувийн хэвшлийн өсөлтийг дэмжсэн байгаа эсэхэд хяанлт тавих;

- Ил тод байдлын гэрээг бүрэн хэрэгжүүлэхтэй холбоотой Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг олон нийтээс санал авах, шинээр батлагдсан хуулиудыг англи хэл рүү хөрвүүлэх зэрэг асуудлыг бодлого боловсруулагчид, яамд, төрийн байгууллагууд хэрэгжүүлэх ажлыг хангана.

Зорилтууд

АмЧам Монголын бодлогын хороодын үйл ажиллагааг дэмжиж, үр дүнтэй чиглүүлэх. Үүнд:

1. Санхүүгийн хороо,
2. Хөдөө аж ахуйн хороо,
3. Хуульзүйн хороо,
4. МХХ, цахим эдийн засгийн хороо,
5. Компанийн нийгмийн хариуцлагын хороо,
6. Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн хороо
7. АНУ-тай харилцах хороо

Бусад чухал оролцогч талуудтай эвсэх, хамтарч үйл ажиллагаа явуулах

Үйл ажиллагаанууд

- Хороодын хурлыг хамгийн багадаа улирал бүр зохион байгуулахд

- Хөрөнгө оруулалт болон ашигт малтмалын тухай хуулийн төслүүд дээр ажиллах ажлын хэсгүүдийг байгуулах;

- Хороодын үйл ажиллагаанд гишүүдийг идэвхитэй оролцуулахд

- Холбогдох сэдвүүдээр бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэхд

- Шаардлагатай бол хороодын шинэ удирдлагуудыг сонгох

- Бусад худалдааны танхимуудтай, тухайлбал МҮХАҮТ, Бизнесийн Зөвлөл, Европын, Британийн болон Австралийн худалдааны танхимуудтай хамтран ажиллах, санал нэгдсэн бодлогын нөлөөллийн асуудлуудаар төрийн байгууллагуудад хамтарсан мэдэгдэл, саналууд хүргүүлэх

- Бусад худалдааны танхимууд болон гуравдагч хөршийн дипломат төлөөлөгчийн газруудтай бодлогын мессежүүд болон нөлөөллийн ажлуудаа уялдуулах

- Бусад худалдааны танхимууд болон гуравдагч хөршийн дипломат төлөөлөгчийн газруудтай улирал тутмын хурал зохион байгуулах

- Засгийн газартай бодлогын шинэчлэлийг хамтран хэрэгжүүлэх

Хүлээж буй үр дүн

- Хороод идэвхитэй ажиллаж, бодлогын нөлөөллийн ажлуудыг гүйцэтгэсэн эсэх

- Бодлогын асуудлуудаар 5 хүртэлх бодлогын баримт бичиг боловсруулах

- Бусад худалдааны танхимууд болон гуравдагч хөршийн дипломат төлөөлөгчийн газруудтай улирал тутмын хурал зохион байгуулах;

- УИХ, Засгийн газарт хамтарсан саналууд хүргүүлэх;

- Бусад худалдааны танхимууд болон гуравдагч хөршийн дипломат төлөөлөгчийн газруудтай бодлогын мессежүүд болон нөлөөллийн ажлуудаа уялдуулах;

- Засгийн газартай бодлогын шинэчлэлийн асуудлуудаар уулзалтууд зохион байгуулах;

2.2. АНУ болон Монгол улсын хоёр талын болон гуравдагч хөршүүдтэй хийх худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ялангуяа хөдөө аж ахуйн салбарт АНУ-ын хөрөнгө оруулалтыг татах

АНУ болон Монгол улсын хоёр талын харилцаа, тэр дундаа бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон дипломат төлөөлөгчдийн харилцаа холбоог бэхжүүлэн өргөжүүлэх нь АмЧам Монголын эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой билээ. Хоёр улсын хооронд одоо байгаа хууль эрх зүйн орчны хүрээнд, түүнд тулгуурлан хоёр талт худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зорилгоор богино, дунд, урт хугацааны зорилтуудыг тусгасан илүү уялдаатай, төвлөрсөн гуравдагч хөршийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх болно.

Монголын хөдөө аж ахуйн салбарт бордоо зэрэг зайлшгүй шаардлагатай орцуудын нийлүүлэлт тасалдсан, зах зээлийн тодорхойгүй байдал зэрэг урьд өмнө байгаагүй сорилтуудтай тулгарч байна. АНУ-ын Засгийн газар эдийн засгийн тогтвортой, уян хатан өсөлт, хүнсний аюулгүй байдлыг дэмжихийн тулд Монголын түншүүдтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал, АНУ-ын Хөдөө Аж Ахуйн Яам (USDA)-ны Food for Progress хөтөлбөр нь хөгжиж буй орнуудад хөдөө аж ахуйн бүтээмжийг сайжруулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдааг дэмжихэд тусалдаг. Хүлээн авагч орнуудад хандивласан АНУ-ын хөдөө аж ахуйн түүхий эдийг орон нутгийн зах зээлд борлуулж, олсон орлогыг хөдөө аж ахуй, эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөрийг дэмжихэд зарцуулдаг. Хөтөлбөр нь хүнсний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх, уур амьсгалд тохирсон хөдөө аж ахуйг хөгжүүлэх, худалдааг хөнгөвчлөхөд тусалдаг. Өдгөө АНУ-ын хөгжлийн агентлагаас Монгол Улсад таван жилийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн давуу талыг ашиглан хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг ахиулах Монгол, АНУ-ын хоёр талын түншлэлийг тариаланчид, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд техникийн туслалцаа үзүүлэх, чадавхийг бэхжүүлэх, сургалтад хамруулах замаар өргөжүүлэх боломжтой.

Монгол улс, АНУ болон бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдийн хооронд худалдаа, нөлөөллийн ажлын хүрээнд нягт хамтран ажиллах нь бизнес, худалдааг нэмэгдүүлэх, хувийн хэвшилд тулгуурласан өсөлтийг бий болгох, Монголын эдийн засгийг эрчимжүүлэхэд чухал ач холбогдолтой. АмЧам Монгол нь 2024 онд хийх нэг чухал ажил нь АНУ руу шууд нислэг үйлдэх бөгөөд энэ нь АНУ, Монгол хоёр талын худалдаа, худалдааны харилцааг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. АмЧам Монгол нь 2024 онд АНУ руу шууд нислэгийг амжилттай эхлүүлэхийн тулд АНУ болон Монголын холбогдох талуудыг оролцуулан шаардлагатай зөвлөгөөнүүдийг зохион байгуулна.

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

2. АНУ болон Монгол улсын хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн харилцаа холбоо, түншлэлийг бэхжүүлэх;

Зорилтууд

Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд АНУ, Монгол улсын хоорондын худалдааг нэмэгдүүлэхэд чиглэсэн боломжуудыг судлах;

Хувийн бизнесүүдийн хооронд хамтран ажиллах боломжуудыг тодорхойлж дэмжих, АНУ-ын Монгол дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх: АНУ-ын бизнесийн оролцоог манай гишүүн бизнес эрхлэгчдийн ашиг тусын тулд нэмэгдүүлэх, АНУ-ын төрийн байгууллагуудаас манай гишүүдэд хэрэгтэй хөтөлбөр, бодлогод үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх.

Үйл ажиллагаанууд

- АНУ руу хийх бизнес (Doorknock, Certified Trade Mission 2024) аялалуудыг зохион байгуулах;

- Хөдөө аж ахуй болон бусад салбарт АНУ-ын хөрөнгө оруулалтыг улам нэмэгдүүлэх зорилгоор Certified Trade Mission 2024 бизнес аялал зохион байгуулах;

- USDA-ын Food for Progress хөтөлбөртэй хамтран ажиллах;

- АНУ руу шууд нислэг үйлдэх асуудлаар Америкийн болон Монголын оролцогч талуудыг оролцуулан хэлэлцүүлэг, цахим уулзалтууд зохион байгуулах;

- 2024 онд Хөрөнгө оруулалтын чуулганыг санаачилж, Засгийн газар болон хувийн хэвшлийн талуудтай хамтран зохион байгуулах;

- АНУ-тай харилцах шинэ хороог байгуулах

Хүлээж буй үр дүн

- Бидний бодлогын гол мессэжүүдийг АНУ-ын холбогдох бодлого тодорхойлогчдод хүргэх;

- Хөдөө аж ахуйн салбарт АНУ-ын хөрөнгө оруулалт өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн байх;

- Бодлогын нөлөөллийн гол асуудлуудаар идэвхитэй үр дүн гарах хүртэл ажиллах;

- АНУ руу шууд нислэг амжилттай үйлдсэн байх;

- 2024 оны Хөрөнгө оруулалтын чуулганыг амжилттай зохион байгуулах;

- АНУ-тай харилцах хороог байгуулж, амжилттай ажиллуулах;

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

2. АНУ болон Монгол улсын хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүс нутгийн харилцаа холбоо, түншлэлийг бэхжүүлэх;

Зорилтууд

Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам болон Америкийн холбогдох талуудтай тогтмол мэдээлэл солилцох замаар хамтарсан санаачлагуудыг идэвхитэй хэрэгжүүлэх

Бодлогын асуудлуудаар яриа хэлэлцээ, хэлэлцүүлгийг өргөжүүлэх, бүс нутгийн болон дэлхийн бизнесийн удирдагчид, бусад оролцогч талуудыг урьж оролцуулах;

Үйл ажиллагаанууд

- АНУ-ын төрийн өндөр албан тушаалтнуудыг Монгол улсад айлчлуулах, Монголын төрийн өндөр албан тушаалтнуудыг АНУ-д айлчлуулах ажлыг зохион байгуулах;

- АНУ-ын Конгрессын Монголын бүлэг болон УИХ дахь Монгол-АНУ-ын парламентын бүлэгтэй идэвхитэй хамтран ажиллах;

- Ази, номхон далайн орнуудын Америкийн худалдааны танхимуудын Зөвлөл (ААР)-ийн бүсийн бага хуралд Монгол улсын төлөөлөгчдийг оролцуулж, Монголд бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлээр бүс нутгийн тэргүүний туршлагаас суралцах боломжоор хангах;

Хүлээж буй үр дүн

- Бодлогын гол мессежүүдийг АНУ-ын холбогдох бодлого тодорхойлогчдод хүргэх;

- Бодлогын нөлөөллийн гол асуудлуудаар идэвхитэй үр дүн гарах хүртэл ажиллах;

- АНУ-ын оролцогч талуудад АмЧамын бодлогын талаарх сүүлийн үеийн мэдээллийг улирал тутам явуулах;

- АНУ-ын холбогдох албан тушаалтнууд болон бизнесүүдтэй цахим уулзалтууд зохион байгуулах;

- Гишүүн байгууллагуудыг Энэтхэг – Номхон Далайн Бүс дэх бусад АмЧам-уудтай холбоо тогтооход дэмжих;

3. Гишүүн байгууллагуудын ашиг сонирхолд нийцсэн дэмжлэг үзүүлэх, тэдний брэндийг сурталчлан таниулах

АмЧам Монголын гишүүд нь Монгол улсад ашигт малтмал болон ашигт малтмалын бус салбарт хөрөнгө оруулалт хийж, бизнес эрхэлж байна. Манай гишүүд хамгийн шинэлэг технологи, машин техник, тоног төхөөрөмж, шилдэг туршлагыг ашигласнаар тухайн салбарт олон улсад өрсөлдөх чадвартай болох, илүү их орлого олох, хүрээлэн буй орчныг хамгаалах, ажлын байр бий болгох, орчин үеийн боловсон хүчний ур чадварыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах чадамжийг бий болгодог. Түүгээр ч зогсохгүй манай гишүүд авлигын эсрэг хүчин чармайлтыг дэмжиж улмаар олонхи нь АНУ-ын Гадаад дахь Авлигатай тэмцэх тухай (the U.S. Foreign Corrupt Practices Act) хуулийг дагаж мөрддөг.

АмЧам Монгол нь гишүүддээ төдийгүй хөдөө аж ахуй, санхүүгийн үйлчилгээ, эрчим хүч болон бусал салбарт үйл ажиллагаа эрхэлдэг Америкийн компаниудад боломжийг бий болгох зорилтоо үргэлжлүүлж, гишүүдээрээ дамжуулан Монгол улсад хөрөнгө оруулалт татах, дэвшилтэт технологи, ноу-хауг нэвтрүүлэхийн төлөө ажиллах болно.

АмЧам гишүүддээ зориулсан дэмжлэг үзүүлж, тэдний брэндийг таниулах олон арга замуудыг эрэлхийлэх болно. АмЧам Монгол нь гишүүдийнхээ онцлог хэрэгцээг хангах, гишүүдийн хэрэгцээ шаардлагад тохирсон бодлогын нөлөөллийн ажил явуулах, гишүүдийг АмЧам Монголын арга хэмжээ, үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах, хороодын хурал, ивээн тэтгэх, нэтворкинг хийх боломжуудыг хангахын тулд AmCham Membership Relations Tracker-ыг тогтмол шинэчилж, үүгээрээ дамжуулан гишүүдтэйгээ харилцах харилцаагаа сайтар хянаж байх болно.

Энэ хүрээнд төлөвлөж буй тодорхой ажлуудыг дурьдвал:

3. Гишүүдийнхээ ашиг сонирхолд нийцсэн дэмжлэг үзүүлэх, тэдний брэндийг сурталчлан таниулах

Зорилтууд	Үйл ажиллагаанууд	Хүлээж буй үр дүн
Гишүүдийн хэрэгцээ шаардлагад тохирсон бодлогын нөлөөллийн ажлуудаар дамжуулан тэдэнд үйлчлэх;	• Гишүүдийн хэрэгцээ, шаардлагад яаралтай хариу өгч, холбогдох засгийн газрын байгууллагатай холбогдох; • Тодорхой асуудлуудыг дэвшүүлж, оновчтой шийдэлд хүргэх талаар тууштай ажиллах;	• Гишүүдийн зүгээс АмЧам Монголын бодлогын нөлөөллийн ажилд сэтгэл хангалуун байх; • Гишүүдийн асуудлуудыг нааштайгаар шийдвэрлэх;
Улс төр, эдийн засаг, бодлогын хөгжлийн талаар цаг тухайд нь чанартай мэдээлэл, дүн шинжилгээг гишүүдэд хүргэх;	• Долоо хоног тутмын Бодлогын тоймыг гишүүдийн саналууд дээр үндэслэн сайжруулж, боловсруулах;	• 7 хоног тутмын Бодлогын тоймыг чанартай боловсруулж, гишүүдэд түгээх, бодлогын асуудлаар мэдээлэл авдаг гол суваг болгох; • Гишүүдэд зориулж, шинээр үүссэн улс төр, эдийн засаг, бизнесийн асуудлаар 5 хүртэл бодлогын мэдээлэл бэлтгэж хүргэх;

Зорилтууд

Гишүүн байгууллагуудын брэндийг сурталчлах

Гишүүдтэйгээ харилцах харилцаанд мониторинг хийх

Гишүүдийнхээ шилдэг туршлага, амжилтыг таниулах замаар Монголын бизнес эрхлэгчдийн нийгмийн хариуцлагын соёлыг түгээн дэлгэрүүлэх

Үйл ажиллагаанууд

- Олон сувгуудаар дамжуулан гишүүн байгууллагуудын брэндийг сурталчлах, бодлогын хороод, арга хэмжээ, нэтворкинг уулзалтуудад идэвхитэй гишүүдийнхээ хувь нэмрийг нь үнэлэх;

- AmCham Membership Relations Tracker-г тогтмол шинэчлэх;
- Одоо бүртгэлтэй гишүүдийн тоог хэвээр хадгалах;

АмЧам Монголын Компанийн Нийгмийн хариуцлагын хороо болон жил бүрийн AmCham CSR Awards Night-аар дамжуулан гишүүдийнхээ Компанийн нийгмийн хариуцлагын шилдэг туршлага, амжилтуудыг олон нийтэд таниулах

Хүлээж буй үр дүн

- Гишүүдийн нэр, брэнд олон нийтэд илүү танигдсан байх;
- Гишүүдийн талархлыг хүлээх

- AmCham Membership Relations Tracker-г улирал бүр шинэчлэх;
- Одоогийн 81 гишүүнийг хэвээр хадгалах;
- Гишүүнчлэлийн хадгалалтын харьцаа: 90%

- CSR Awards Night 2024-ыг амжилттай зохион байгуулах
- АмЧам Монголын Компанийн нийгмийн хариуцлагын шагналыг хүртсэн гишүүдийн талаар өдөр тутмын сонинд хэвлэлийн мэдээ гаргах